



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/118

Булган сум

**Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 28 дугаар зүйлийн 28.4, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс үхэж хорогдсон мал, амьтны сэг, зэмийг устгах, бэлчээр, хашаа хороо, өвөлжөө, хаваржаа болон худаг, уст цэгийн орчныг цэвэрлэж, ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг 2024 оны 03 дугаар сарын 05-наас 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Дээрх ажилд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), мал, амьтны сэг, зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд орон нутгийн байгууллага, малчдыг өргөнөөр оролцуулах, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Д.Жаргалсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ